

ОРОСЫН ШИНЭ АВТОМАТ АН-94.

1995 онд автомат зэвсэг зохион бүтээгч Никоновын шинэ автомат АН-94 буюу "Абакан" ОХУ-ын армийн зэвсэглэлд орохоор боллоо. Энэ автомат яваандаа одоогийн оросын армийн зэвсэглэлд байгаа хүн нэг бүрийн зэвсэг АК-74-ийг бүгдийг халж магадгүй юм. Ер нь тэдний буудлагын зэвсгийг бусад орныхтой харьцуулахад сумны тусгал бөөн, бай онох магадлал илүү байдгаараа давуу талтай юм. Шинээр зохион бүтээгдсэн АН-94 нь өнөөгийн зэвсэглэлд байгаа автомат буунаас техникийн давуу талтай харагдавч дэлхийн аль нэг халуун цэг дээр түүнийг туршиж үзээгүй, ашиглалтын явцад ямар эд анги тохиромжгүй болох нь тогтоогдоогүй байна. Улс хоорондын сүүлийн үеийн дайны байдлаас ажиглахад хүн нэг бүрийн зэвсэглэлийг өөрчлөх шаардлагатай болсон гэдгийг мэргэжилтнүүд үзэж байгаа юм. Шинэ автомат "Абакан" гадна төрх байдлаараа одоогийн Оросын армийн зэвсэглэлд байгаа автомат АК-74-тэй нэлээд төстэй. Шинэ автоматны сумны калибрь 5.45 мм /хонгионы урт 39 мм/ ийм голчтой сумыг үйлдвэрлэж байгаа боловч ер нь аль ч улсын нутаг дэвсгэрт 7.62 мм-ийн голчтой сумаар буудлага үйлдэхэд байг онох магадлал илүү байгааг харгалзан шинэ бууны сумны голчийг цаашид 7.62 болгон өөрчилж үйлдвэрлэх болж байна. Калашниковын автомат өнөөдөр ч дэлхийн бүх зэвсэг зохион бүтээгдчийн талархлыг хүлээсэн хэвээр байгаа билээ. "Абакан" автомат гар бариултай, буудлагын үед Калашниковын автоматтай ижил дайзнаас тэжээгддэг. Үүгээрээ энэ хоёр автомат ижилхэн, зохиогч Геннадий Никонов шинэ автоматаа хийхдээ хийн яндангүй байхаар тооцсон, гадаад төрхийг нэлээд орчин үеийн загвар хэлбэрт оруулсан галын 3 дахь төрлийг шинээр сэдэж олсноороо давуу талтай. Абакан автомат нэгийн галаар буудахдаа л хос сум гаргадаг. Барууны орнуудад нэг буудалтаар 3 ширхэг сум гаргадаг автомат ажиллагатай буунуудыг "Галил", "Клерон", "АУГ" гэх мэт/үйлдвэрлэн гаргаж байгаа боловч АН-94 нэг секундэд 4 ширхэг сумыг /2+2/ гаргана. Буудлагын үед буунд ухралтын хүч гэж байдаггүй 1 минутад 1800 ш сум буудах чадалтай нь энэ бууны гол нууц юм. Богино ээлжийн галаар байг целийг огт алдаж буудахгүй. Тэр үед бууг мөрлөх ч шаардлагагүй. Эхний цахилгаан цохих мэт 2 буудалтын дараахь галны үргэлжлэл нь галын өөр төрөлд шилжин буудлагын хурд нь Калашниковын автоматны буудлагын хурдтай ижил болж өөрөөр хэлбэл секундэд 10 ш сум гаргана.

Орчин үеийн бага калибрийн автомат буу эхний сумаар эсрэг

буудагчаа устгаж байгаа ба өрсөж буудагч өөрөө энэ үед нуугдаж амжсан баыхыг тухайн нөхцөл байдал шаардахаас гадна өнөөдрийн үйлдвэрээс гарч байгаа буудлагын зэвсгийн чадал мэдэгдэхүйц сайжирсан гэдэг нь амьдрал дээр батлагдсан юм. Эхний сумаа буудчихаад байрлалаа сольж дахин буудалцах боломжгүй. Өөрөөр хэлбэл хэн өрсөн нь нэгийгээ устгана. Сайн буудагч Никоновын автоматаар алдаж буудах үндэслэлгүй, зөвхөн шагайх цэгээ зөв сонгосон байх л хэрэгтэй. Мэргэн буудагчийн винтовын нэг адил мэргэн тусах ба харааны буудах холын тусгал нь 1000 м.

"Абакан" автомат нь АК-74-өөс хөнгөн, байнд тасралтгүй галаар олон сум буудахад сумны хошууны тусгалын цацралт маш бага. 100-м-ийн зайд байгаа байнд 30 ш сумаар буудахад тусгалын бөөгнөрөл нь 15 см голчтой тойрогт бүгд багтсан байдаг байна. Түүний буудлагын үеийн дуу АК-74-өөс бага. Иймд мэргэн буудагчийн зэвсэг болгоход илүү тохиромжтойг үзсэн хүн бүр зөвлөсөн байна. /Дайсан мэргэн буудагчийн хаанаас буудаж байна гэдгийг олж мэдэх ёсгүй/ Никоновын энэ автоматыг барууны зэвсгийн бүх мэргэжилтнүүд гаргууд сайн хийгдэж гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа ба НАТО-гийн буудлагын зэвсгийг эхний 2 сум гаргахад ухралтгүй болгох зорилго тавьж ажиллаж байна.

Никоновын автомат бүтцийн хувьд тийм ч хялбар биш ч нарийн хийцтэй тул олноор үйлдвэрлэж зэвсэглэлд оруулахад эдийн засгийн тооцооны үүднээс нэлээд хүндрэлтэй юм. Харин энэ зэвсгийг мэргэн буудагчийн винтовын оронд хэрэглэхээр үйлдвэрлэвэл одоохондоо Оросын армийн эдийн засагт ашигтай буюу АК-74 автомат нь АНУ-ын автомат-винтов М16-аас муугүй, харин ч эдэлж хэрэглэхэд эвтэйхэн, найдвартай ажиллагаатай юм.

Цаашид АК-74 автоматны калибрийг 7.62 мм болгон өөрчилбөл хэвээр хадгалж XXI зуунд ч олон жил явган цэргийн үндсэн зэвсэг хэвээр байх магадлал байгаа ажээ. Гэвч олон орны армиудад хийж байгаа цэргийн шинэчлэл, орон тооны цомхоттол, мэргэжлийн армитай болох гэж байгаа зорилго зэрэг шалтгаанаас АН-94 автоматыг олноор үйлдвэрлэж зэвсэглэлд нэвтрүүлэхийг үгүйсгэх аргагүй юм.



Дэд профессор хурандаа
3.Пүрэвдорж